

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
БҮХИЙ ХОРШООДЫН 2009 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2010.02.22

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант жилд Хорооны хуралдаанаар 15 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 12 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 8 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээр шийдвэрлэснээр 2009 оны жилийн эцсийн байдлаар нийт 212 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх 212 хоршоодоос 161 буюу 75.9 хувь нь зохих журмын дагуу 2009 оны жилийн эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 51 буюу 24.1 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээгээ хугацаандаа ирүүлээгүйгээс тэдгээрийн Хороонд ирүүлсэн хамгийн сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар нэгтгэлд хамрууллаа.

Жилийн эцсийн байдлаарх ирүүлбэл зохих санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлсэн 161 хоршооны тайлан мэдээг ирүүлсэн хугацаагаар нь авч үзвэл журмын дагуу хугацаандаа ирүүлсэн 42 хоршоо, 10 хүртэл хоног хоцроосон 80 хоршоо, 11-20 хүртэл хоног хоцроосон 39 хоршоо байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж байгаа байдлыг харуулбал дараах байдалтай байна.



Харин 2008 оны жилийн эцсийн байдлаар нийт гишүүдийн тоо 24,655 байсан бол тайлант жилд хадгаламж, зээлийн хоршоодын нийт гишүүдийн тоо 28,069 болж өссөн байна.



Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл				Хоршоодын тоо
	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	түдгэлзүүлснийг сэргээсэн	
2006	51	0	0	-	51
2007	128	0	0	-	179
2008	45	15	5	-	209
2009	15	12	8	1	212

Харин 2006 онд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 51 хоршооноос 16 хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008-2009 онуудад хүчингүй болгосон, үйл ажиллагаа явуулж байгаа 35 хоршооноос 25 хоршооны тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар сунгасан байна.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2009 онд	2008 онд
1	ХЗХ-дын тоо	212	209
2	Гишүүдийн тоо	28,069	24,655
3	Нийт актив /мянган төгрөгөөр/	44,568,177.8	41,700,338.9
	Банкны салбарт эзлэх хувь	1.0%	1.1%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	32,215,209.7	32,377,976.3
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	2,128,058.1	2,192,021.6
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%	1.2%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	29,898,255.7	27,671,713.7
	Банкны салбарт эзлэх хувь	1.7%	2.1%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	7,442,560.6	7,668,248.4
	Банкны салбарт эзлэх хувь	2.8%	*
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	4,469,339.6	3,204,105.3
	Банкны салбарт эзлэх хувь	1.9%	*
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	601,225.9	752,132.3
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	209,460.7	473,506.6
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	14,527,593.3	12,699,436.6
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	12,690,728.1	10,804,548.8
13	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,836,865.2	1,894,887.8
14	Активын өгөөж /ROA/	4.81 %	5.4%
15	Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	15.42 %	17.8%

Жич: *-тооцоолох боломжгүй.

2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын талаар

1	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	95	101
	Гишүүдийн тоо	13,176	12,579
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	46.9%	51.0%
1.1	Нийт актив /мянган төгрөгөөр/	38,248,248.3	35,243,092.77
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	85.8%	84.5%

1.2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	27,466,520.9 85.3%	27,216,122.63 84.1%
1.3	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	1,494,904.3 70.2%	* *
1.4	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	26,836,866.3 89.8%	24,180,150.1 87.4%
1.5	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	5,546,641.5 74.5%	6,016,816.5 78.5%
1.6	Нийт хоршоологчдын өмчийн дүнд /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	4,106,063.4 91.9%	* *
1.7	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүнд /мянган төгрөгөөр/	81,221.2	*
1.8	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүнд /мянган төгрөгөөр/	46,865.4	*
1.9	Нийт орлого /мянган төгрөгөөр/	12,799,413.7	*
1.10	Нийт зардал /мянган төгрөгөөр/	11,118,347.1	*
1.11	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	1,681,066.6	*

Жич: *- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоон үзүүлэлтийг гаргах боломжгүй.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 95 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 46.9 хувийг, тэдгээрийн нийт актив 38,248,248.3 мянган төгрөг байгаа нь нийт активын 85.8 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 95 хоршоо нь 12,799,413.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 88.1 хувийг, харин 11,118,347.1 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 87.6 хувийг тус тус эзэлж байна.

2.2 Орон нутаг үйл ажиллагаа явуулж буй хоршоодын талаар -

2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	117	108
	Гишүүдийн тоо	14,893	12,076
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	53.1%	49.0%
2.1	Нийт актив /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	6,319,929.5 14.2%	6,457,246.1 15.5%
2.2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	4,748,688.7 14.7%	5,161,853.7 15.9%
2.3	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	633,153.8 29.8%	* *
2.4	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	3,061,389.4 10.2%	3,491,563.6 12.6%
2.5	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	1,895,919.1 25.5%	1,651,431.9 21.5%
2.6	Нийт хоршоологчдын өмчийн дүнд /мянган төгрөгөөр/ ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	363,276.2 8.1%	* *
2.7	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүнд /мянган төгрөгөөр/	520,004.7	*
2.8	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүнд /мянган төгрөгөөр/	162,595.3	*
2.9	Нийт орлого /мянган төгрөгөөр/	1,728,179.6	*
2.10	Нийт зардал /мянган төгрөгөөр/	1,572,381.0	*
2.11	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	155,798.6	*

Жич: *- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоон үзүүлэлтийг гаргах боломжгүй.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 117 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл

ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 53.1 хувийг, тэдгээрийн нийт актив 6,319,929.5 мянган төгрөг байгаа нь нийт активын 14.2 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 117 хоршоо нь 1,728,179.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 11.9 хувийг, харин 1,572,381.0 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 12.4 хувийг тус тус эзэлж байна.



2.3 Хасбанктай франчайзийн гэрээтэй ажиллаж буй хоршоод

3	Хас банктай франчайзийн үйлчилгээний гэрээтэй ХЗХ-дын тоо	72
<i>ХЗХ-дын нийт тоонд эзлэх хувь</i>		34.0%
3.1	Нийт актив /мянган төгрөгөөр/ <i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	2,768,175.8 6.3%
3.2	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ <i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	2,244,593.5 7.0%
3.3	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ <i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	84,943.8 1.8%
3.4	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/ <i>ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	580,076.9 1.9%
3.5	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мянган төгрөгөөр/ <i>ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	1,063,663.3 14.3%
3.6	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мянган төгрөгөөр/ <i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	389,381.2 10.0%
3.7	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	512,752.0
3.8	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мянган төгрөгөөр/	157,595.3
3.9	Нийт орлого /мянган төгрөгөөр/	942,248.6
3.10	Нийт зардал /мянган төгрөгөөр/	661,393.4
3.11	Тухайн үеийн ашиг /мянган төгрөгөөр/	280,855.2

Жич: *- Хасбанктай франчайзийн гэрээтэй хоршоодын үзүүлэлтүүдийг тооцоолох боломжгүй.

Франчайзийн гэрээтэй хоршоодын орлого, зарлагын тайлангаас харахад 942,248.6 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт орлогын 6.6 хувийг, харин 661,393.4 мянган төгрөгийн зардал нь нийт зардлын 5.1 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 280,855.2 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Орлогын үзүүлэлтүүд

Тайлант жилд нийт орлогын хэмжээ 14,527,593.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,828,156.7 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар өссөн нь гадаад

валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 2,231,493.4 мянган төгрөгөөр буюу 3.3 дахин өссөнтэй холбоотой байна

Орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд

/мянган төгрөгөөр/

	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ОРЛОГО	10,764,213,840.68	74.1%	11,092,623,442.50	87.3%	- 328,409,601.82	-3.0%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	10,218,971,740.96	70.3%	9,908,986,722.88	78.0%	309,985,018.07	3.1%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	193,878,808.65	1.3%	136,179,222.26	1.1%	57,699,586.39	42.4%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	330,395,011.32	2.3%	1,018,119,678.42	8.0%	- 687,724,667.10	-67.5%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	2,649,416.89	0.0%	756,790.00	0.0%	1,892,626.89	250.1%
Бусад хүүгийн орлого	18,318,862.86	0.1%	28,581,028.94	0.2%	- 10,262,166.08	-35.9%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	674,231,860.98	4.6%	444,415,849.35	3.5%	229,816,011.63	51.7%
Элсэлтийн хураамж	11,093,150.00	0.1%	16,402,769.00	0.1%	- 5,309,619.00	-32.4%
Гишүүний татвар	22,152,754.89	0.2%	18,540,411.89	0.1%	3,612,343.00	19.5%
Үйлчилгээний хураамж	146,521,132.89	1.0%	89,911,753.72	0.7%	56,609,379.17	63.0%
Үйл ажиллагааны бусад орлого	494,464,823.20	3.4%	319,560,914.74	2.5%	174,903,908.46	54.7%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	3,089,147,620.54	21.3%	1,162,397,281.28	9.2%	1,926,750,339.26	165.8%
Торгуулийн орлого	5,881,330.00	0.0%	1,420,000.00	0.0%	4,461,330.00	314.2%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	12,949,949.00	0.1%	13,490,733.16	0.1%	- 540,784.16	-4.0%
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	-	0.0%	158,455,257.21	1.2%	- 158,455,257.21	- 100.0%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	2,908,584,625.52	20.0%	677,091,178.52	5.3%	2,231,493,447.00	329.6%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	1,340,999.00	0.0%	3,409,532.66	0.0%	- 2,068,533.66	-60.7%
Бусад орлого	147,926,281.28	1.0%	139,946,167.03	1.1%	7,980,114.25	5.7%
Онцгой шинжтэй орлого	10,323,000.00	0.1%	159,769,259.70	1.3%	- 149,446,259.70	-93.5%
Ердийн бус орлого	2,141,435.74	0.0%	8,815,153.00	0.1%	- 6,673,717.26	-75.7%
Нийт орлогын дүн	14,527,593,322.20	100.0%	12,699,436,573.13	100.0%	1,828,156,749.07	214.5%

Тайлант жилийн орлогын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон. Тухайлбал; зээлийн хүүгийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин 87.3-74.1 хувь болж буурсан, харин хүүгийн бус орлогын нийт орлогод эзлэх хувийн жин 3.5-4.6 хувь болж өссөн байна.

Тайлант жилд нийт орлогын 70.3 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 20.0 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, үлдэх 9.7 хувийг бусад орлого эзэлж байна..

3.2 Зардлын үзүүлэлтүүд

Тайлант жилд нийт зардлын хэмжээ 12,690,728.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,886,179.3 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн ба үүнд үйл ажиллагааны бус зардлын өсөлт нөлөөлжээ.

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ

ХҮҮГИЙН ЗАРДАЛ	6,169,097,861.26	48.6%	6,516,367,817.32	60.3%	- 347,269,956.06	-5.3%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	2,510,039,541.25	19.8%	2,644,748,443.07	24.5%	-134,708,901.82	-5.1%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	3,262,011,917.11	25.7%	3,289,501,873.45	30.4%	-27,489,956.34	-0.8%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	221,232,184.59	1.7%	141,187,565.72	1.3%	80,044,618.87	56.7%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	146,066,933.31	1.2%	432,575,975.08	4.0%	-286,509,041.77	-66.2%
Бусад хүүгийн зардал	29,747,285.00	0.2%	8,353,960.00	0.1%	21,393,325.00	256.1%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	802,734,547.21	6.3%	1,026,666,081.05	9.5%	- 223,931,533.84	-21.8%
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	794,962,741.01	6.3%	1,011,633,959.42	9.4%	- 216,671,218.41	-21.4%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	3,299,438.70	0.0%	12,982,400.43	0.1%	-9,682,961.73	-74.6%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	3,502,063.70	0.0%	850,000.00	0.0%	2,652,063.70	312.0%
Бусад эрсдэлийн зардал	970,303.80	0.0%	1,199,721.20	0.0%	-229,417.40	-19.1%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,264,221,315.77	17.8%	2,362,736,825.47	21.9%	-98,515,509.70	-4.2%
Боловсон хүчний зардал	1,282,343,158.20	10.1%	1,262,499,692.11	11.7%	19,843,466.09	1.6%
Бусад зардал	981,878,157.57	7.7%	1,100,237,133.37	10.2%	-118,358,975.79	-10.8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	3,454,674,384.51	27.2%	898,778,040.20	8.3%	2,555,896,344.31	284.4%
Торгуулийн зардал	13,992,545.00	0.1%	7,159,882.59	0.1%	6,832,662.41	95.4%
Ногдол ашгийн зардал	4,006,335.00	0.0%	22,805,341.62	0.2%	-18,799,006.62	-82.4%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	1,794,410.00	0.0%	1,844,871.00	0.0%	-50,461.00	-2.7%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	2,891,684,369.29	22.8%	589,764,055.28	5.5%	2,301,920,314.01	390.3%
Үйл ажиллагааны бус бусад зардал	299,336,331.52	2.4%	33,814,251.86	0.3%	265,522,079.66	785.2%
Ердийн бус зардал	5,400,213.85	0.0%	2,221,973.00	0.0%	3,178,240.85	143.0%
Татварын зардал	238,460,179.85	1.9%	241,167,664.85	2.2%	-2,707,485.00	-1.1%
Нийт зардлын дүн	12,690,728,108.76	100.0%	10,804,548,764.05	100.0%	1,886,179,344.71	17.5%

Тайлант жилийн зардлын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон. Тухайлбал; хүүгийн зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 60.3-48.6 хувь болж буурсан, харин хүүгийн бус зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 8.3-27.2 хувь болж өссөн байна.

Тайлант жилд нийт зардлын 48.6 хувийг хүүгийн зардал, 17.8 хувийг үйл ажиллагааны зардал, 27.2 хувийг үйл ажиллагааны бус зардал, 6.4 хувийг болзошгүй эрсдэлийн сангийн зардал эзэлж байна. Харин нийт зардлын 22.8 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал эзэлж байгаа бөгөөд энэ зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,301,920.3 мянган төгрөгөөр буюу 4.9 дахин өссөн байна.

3.3 Алдагдалтай ажиллаж буй хоршоод

Тайлант жилд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын 44 хоршоо буюу 20.8 хувь нь нийт 576,217.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.

д/д	Үзүүлэлтүүд	Хоршоодын тоо	Нийт алдагдал	Эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	1	162,062,751.00	28.1%
2	50,000.0-100,000.0 мянган төгрөг	3	250,207,089.16	43.4%
3	10,000.0-50,000.0 мянган төгрөг	6	91,236,615.24	15.8%

4	5,000.0-10,000.0 мянган төгрөг	5	35,494,349.98	6.2%
5	1,000.0-5,000.0 мянган төгрөг	12	31,308,048.22	5.4%
6	500.0-1,000.0 мянган төгрөг	4	3,347,713.46	0.6%
7	500.0 мянган төгрөг хүртэл	13	2,561,114.57	0.4%
	Нийт дүн	44	576,217,681.63	100.0%

Нийт алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын 63.6 хувь буюу 28 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн алдагдал 315,790.9 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 54.8 хувийг эзэлж байна.

Орон нутагт алдагдалтай ажиллаж байгаа 16 хоршооны алдагдал 260,426.8 төгрөг нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 45.2 хувийг, үүнээс Хасбанктай франчайзийн гэрээтэй 9 хоршоо нийт 6,541.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 2.5 хувийг эзэлж байна.

3.4 Ашигтай ажиллаж буй хоршоод

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэж буй нийт хоршоодоос 168 хоршоо буюу 79.2 хувь нь 2,413,082.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан.

Ашгийн хэмжээгээр хоршоодыг ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Ашгийн үзүүлэлтүүд	Хоршооны тоо	Нийт ашиг	Ашигт эзлэх хувь
1	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	1,069,151,446.98	44.3%
2	100,000.0-300,000.0 мянган төгрөг	2	349,292,000.18	14.5%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	4	296,203,070.91	12.3%
4	20,000.0-50,000.0 мянган төгрөг	11	274,133,656.64	11.4%
5	10,000.0-20,000.0 мянган төгрөг	10	135,912,895.16	5.6%
6	5,000.0-10,000.0 мянган төгрөг	14	100,911,029.71	4.2%
7	1,000.0-5,000.0 мянган төгрөг	68	162,963,884.33	6.8%
8	500.0-1,000.0 мянган төгрөг	22	16,422,292.57	0.7%
9	100.0-500.0 мянган төгрөг	26	7,813,816.40	0.3%
10	100.0 мянган төгрөг хүртэл	7	278,802.20	0.0%
11		3	0.00	0.0%
	Нийт дүн	168	2,413,082,895.08	100.0%

Нийт ашигтай ажиллаж байгаа хоршоодын 42.3 хувь буюу 71 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн ашиг 2,006,314.8 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 83.1 хувийг эзэлж байна.

Орон нутагт ашигтай ажиллаж байгаа 97 хоршооны ашиг 406,768.1 мянган төгрөг нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 16.9 хувийг, үүнээс Хасбанктай франчайзийн гэрээтэй 60 хоршоо нийт 279,730.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан хоршоодын нийт ашгийн 68.8 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын чанар

Хоршоодын тайлант жилийн нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	43,101,802.09	96.7%	40,361,741.3	96.8%	2,740,060.8	6.8%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,779,467.68	21.9%	7,109,734.0	17.0%	2,669,733.7	37.6%
1.Касс дахь бэлэн мөнгө	1,580,187.55	3.5%	1,751,594.3	4.2%	(171,406.8)	-9.8%
2.Банкинд байршуулсан харилцах	4,466,616.25	10.0%	2,579,868.5	6.2%	1,886,747.7	73.1%
3.Банкинд байршуулсан хадгаламж	3,732,663.88	8.4%	2,745,387.4	6.6%	987,276.5	36.0%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах	-	0.0%	32,522.6	0.1%	(32,522.6)	-100.0%
5.Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	-	0.0%	361.2	0.0%	(361.2)	-100.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	30,368,474.95	68.1%	30,653,312.2	73.5%	(284,837.3)	-0.9%
8. Нийт зээл	32,215,209.67	72.3%	32,377,976.3	77.6%	(162,766.6)	-0.5%
8.1.Хэвийн зээл	25,615,400.65	57.5%	29,006,400.8	69.6%	(3,391,000.1)	-11.7%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	4,471,750.92	10.0%	1,179,553.8	2.8%	3,292,197.1	279.1%
8.3.Чанаргүй зээл	2,128,058.10	4.8%	2,192,021.7	5.3%	(63,963.6)	-2.9%
8.3.1. Хэвийн бус	314,024.84	0.7%	495,375.6	1.2%	(181,350.8)	-36.6%
8.3.2. Эргэлзээтэй зээл	491,661.46	1.1%	496,280.3	1.2%	(4,618.8)	-0.9%
8.3.3. Муу зээл	1,322,371.81	3.0%	1,200,365.8	2.9%	122,006.0	10.2%
8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	1,846,734.73	4.1%	1,724,664.1	4.1%	122,070.6	7.1%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,276,296.34	5.1%	2,076,724.2	5.0%	199,572.1	9.6%
9. Байгууллага, хүмүүсээс авах авлага	222,984.90	0.5%	383,613.3	0.9%	(160,628.4)	-41.9%
10. (Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрсдэлийн сан)	50,355.10	0.1%	43,824.0	0.1%	6,531.1	14.9%
11. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,103,666.54	4.7%	1,736,934.9	4.2%	366,731.6	21.1%
БУСАД ХӨРӨНГӨ	162,388.58	0.4%	160,954.8	0.4%	1,433.8	0.9%
12. Материал үнэ бүхий зүйл	122,715.55	0.3%	102,163.0	0.2%	20,552.5	20.1%
14. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	7,361.31	0.0%	17,292.7	0.0%	(9,931.4)	-57.4%
15. Бусад актив	32,311.72	0.1%	41,499.1	0.1%	(9,187.4)	-22.1%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	515,174.55	1.2%	361,016.1	0.9%	154,158.5	42.7%
16. Өмчлөх бусад хөрөнгө	565,182.53	1.3%	401,739.9	1.0%	163,442.6	40.7%
17. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан)	50,007.97	0.1%	40,723.8	0.1%	9,284.2	22.8%
2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,466,375.73	3.3%	1,338,597.6	3.2%	127,778.1	9.5%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,356,635.79	3.0%	1,199,542.6	2.9%	157,093.2	13.1%
18. Үндсэн хөрөнгө	1,860,980.42	4.2%	1,668,093.0	4.0%	192,887.4	11.6%
19.(Үндсэн хөрөнгийн элэгдэл)	504,344.63	1.1%	468,550.4	1.1%	35,794.2	7.6%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	109,739.94	0.2%	139,055.0	0.3%	(29,315.1)	-21.1%
20. Биет бус хөрөнгө	31,128.66	0.1%	23,743.9	0.1%	7,384.8	31.1%
21.Бусад	78,611.28	0.2%	115,311.1	0.3%	(36,699.8)	-31.8%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	44,568,177.82	100.0%	41,700,338.9	100.0%	2,867,838.9	6.9%

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал; чанаргүй зээлийн нийт активт эзлэх хувийн жин 5.3-4.8 хувь, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 4.2-4.7 хувь болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.



Нийт эх үүсвэр 2,226,542.0 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөнөөр хоршооны нийт актив хөрөнгө өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй ба нийт актив хөрөнгөд хүүгийн орлого авчирдаг актив буюу зээлийн өрийн үлдэгдэл 72.3 хувийг эзэлж байна.

Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	15,636,769,415.13	35.1%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	12,052,316,462.63	27.0%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	5,075,926,227.81	11.4%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	34	6,745,223,770.92	15.1%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	37	2,695,978,010.20	6.0%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	84	2,131,395,958.06	4.8%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	26	187,744,997.20	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	18	42,822,977.36	0.1%
	Нийт дүн	212	44,568,177,819.31	100.0%

Хоршоодын активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 500,000.0-15,636,769.4 мянган төгрөгийн активтай нийт 13 хоршоо байгаа ба тэдгээрийн нийт активын хэмжээ 32,765,012.1 мянган төгрөг нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт активын 73.5 хувийг эзэлж байна.

4.2 Зээлийн багцын чанар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2009.12.31		2008.12.31		ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	30,368,474.9		30,653,312.2		284,837.3	0.9%
Нийт зээл	32,215,209.7	100.0%	32,377,976.3	100.0%	162,766.7	0.5%
Хэвийн зээл	25,615,400.7	79.5%	29,006,400.8	89.6%	3,391,000.2	11.7%
Хугацаа хэтэрсэн зээл	4,471,750.9	13.9%	1,179,553.9	3.6%	-3,292,197.0	-279.1%
Чанаргүй зээл	2,128,058.1		2,192,021.6		63,963.5	
Хэвийн бус	314,024.8	1.0%	495,375.6	1.5%	181,350.7	36.6%
Эргэлзээтэй зээл	491,661.5	1.5%	496,280.3	1.5%	4,618.8	0.9%
Муу зээл	1,322,371.8	4.1%	1,200,365.8	3.7%	-122,006.0	-10.2%
(Зээлийн эрсдэлийн сан)	1,846,734.7		1,724,664.1		-122,070.6	

Тайлант хугацаанд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 284,837.3 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан.

Хоршоодын чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 63,963.5 мянган төгрөг буюу 0.1 хувиар буурч, нийт зээлийн багцын 6.8-6.6 хувийг эзлэх болсон байна.

Зээлийн багцыг графикаар харуулбал:



Зээлийн багцын чанар муудсантай холбоотойгоор зээлийн эрсдлийн сан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.1 хувиар өссөн нь хоршооны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Зээлийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	Нийт зээлд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	10,782,801,520.29	33.5%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	6,540,028,068.11	20.3%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	5,101,337,206.69	15.8%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	26	5,090,407,440.42	15.8%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	39	2,647,830,386.26	8.2%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	78	1,830,219,841.89	5.7%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	19	136,114,136.34	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	33	86,471,073.00	0.3%
9	Зээлийн үлдэгдэлгүй	6	0.00	
	Нийт дүн	212.00	32,215,209,673.00	100.00%

/мянган төгрөгөөр/

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдлийг ангилахад ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 11 хоршоо байгаа ба тэдгээрийн нийт зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ 22,424,166.8 мянган төгрөг нь нийт хоршоодын зээлийн өрийн үлдэгдлийн 69.6 хувийг эзэлж байна.

ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦИЙН ТАЛААР

Хоршоодын тайлант жилийн нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал;

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2009.12.31		2008.12.31		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	32,656,277.69	73.3%	30,827,985.2	73.9%	1,828,292.5	-67.0%
ХАДГАЛАМЖ	29,898,255.73	67.1%	27,671,713.7	66.4%	2,226,542.0	8.0%
1. Хугацаагүй	1,905,561.92	4.3%	2,130,203.7	5.1%	-224,641.8	-10.5%
2. Хугацаатай	27,992,693.81	62.8%	25,541,510.0	61.3%	2,451,183.8	9.6%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	601,225.94	1.3%	753,832.3	1.8%	-52,606.4	-20.2%

3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	598,977.75	1.3%	752,132.3	1.8%	-153,154.6	-20.4%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	2,248.20	0.0%	1,700.0	0.0%	548.2	32.2%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,947,335.31	4.4%	1,928,932.6	4.6%	18,402.7	1.0%
5. Татварын төлөх өглөг	89,288.34	0.2%	43,079.0	0.1%	46,209.3	107.3%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,690,642.98	3.8%	1,661,785.8	4.0%	28,857.2	1.7%
7. Өглөг	110,796.25	0.2%	159,993.7	0.4%	-49,197.5	-30.7%
8. Бусад пассив	56,607.74	0.1%	64,074.1	0.2%	-7,466.4	-11.7%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	209,460.71	0.5%	473,506.6	1.1%	-264,045.9	-55.8%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	209,460.71	0.5%	473,506.6	1.1%	-264,045.9	-55.8%
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	11,911,900.13	26.7%	10,872,353.6	26.1%	1,039,546.5	36.5%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,442,560.57	16.7%	7,668,248.4	18.4%	-225,687.8	-2.9%
10.Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,442,560.57	16.7%	7,668,248.4	18.4%	-225,687.8	-2.9%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	4,469,339.56	10.0%	3,204,105.2	7.7%	1,265,234.4	39.5%
11.Нөөцийн сан	1,179,211.93	2.6%	783,413.6	1.9%	395,798.3	50.5%
12.Дахин үнэлгээний сан	346,608.08	0.8%	61,954.7	0.1%	284,653.4	459.5%
13.Нийгмийн хөгжлийн сан	136,726.63	0.3%	92,603.2	0.2%	44,123.4	47.6%
14.Бусад сангууд	74,602.55	0.2%	94,087.5	0.2%	-19,485.0	-20.7%
15.Хандив, тусламж	57,271.11	0.1%	25,407.0	0.1%	31,864.1	125.4%
16.Бусад өмч	18,247.43	0.0%	2,633.0	0.0%	15,614.4	593.0%
17.Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,836,865.21	4.1%	1,894,887.4	4.5%	-58,022.2	-3.1%
18.Хуримтлагдсан ашиг/алдагдал	819,806.62	1.8%	249,118.8	0.6%	570,687.8	229.1%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	44,568,177.82	100.0%	41,700,338.8	100.0%	2,867,839.0	-30.5%

Тайлант жилд өр төлбөр ба өөрийн хөрөнгөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон.

Тухайлбал, татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,226,542.0 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар, хоршоологчдын өмчийн хэмжээ 1,265,234.4 мянган төгрөгөөр буюу 39.5 хувиар тус тус өссөн. Хоршоологчдын өмчийн өсөлтөд нөөцийн сангийн хэмжээ 395,798.3 мянган төгрөгөөр буюу 50.5 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Харин банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 398,249.5 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 225,687.8 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар тус тус буурсан байна.

Хоршоодын татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/


д/д	Хадгаламжийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт хадгаламжийн үлдэгдэл	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	10,737,418,039.38	35.9%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	4	9,481,270,487.59	31.7%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	5	3,817,918,023.61	12.8%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	16	3,087,671,206.08	10.3%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	14	1,024,319,096.21	3.4%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	57	1,517,767,973.63	5.1%
7	1,000.0-10,000.0 мянган төгрөг	47	218,964,779.99	0.7%
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	29	12,926,127.00	0.0%
9	Хадгаламжгүй	39	-	-
	Нийт дүн	212	29,898,255,733.49	100.0%

Хоршоодын татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 10 хоршоо байгаа ба


тэдгээрийн нийт хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 24,036,606.6 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 80.4 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй 39 хоршоо буюу нийт хоршоодын 18.4 хувь нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн тайлант жилд 7,442,560.6 мянган төгрөг байгаа бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг интервалаар харуулбал дараах байдалтай байна.



Харин хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмчийн бүтэц дараах байдалтай байна.



ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Үүнд:

/мянган төгрөгөөр/

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ТАЙЛАНГААР
А АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН		
1	АКТИВЫН ЭРСДЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	1,870,296,289.43
		1,846,734,727.95 ДУТУУ БАЙГУУЛСАН


2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	6.6% ХАНГААГҮЙ
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0%	0.0%
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	68.1%
5	ӨБҮҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	1.2%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	3.0%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	67.1%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	1.8%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	16.7%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	10.0%
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	670,400,934.0	1,179,211,928.1 ИЛҮҮ БАЙГУУЛСАН
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ		
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	5.1% ХАНГААГҮЙ
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР		
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	18.9%
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)		
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		9.3%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		33.4%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		64.6%

Хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн хувьд активын эрсдлийн санг 23,561.6 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, чанаргүй зээлийн зохистой харьцаа 1.6 хувиар хангагдаагүй, нөөцийн санг байвал зохих хэмжээнээс 508,811.0 мянган төгрөгөөр илүү байгуулсан, үйл ажиллагааны зардлын зохистой харьцааг 0.1 хувиар хэтрүүлсэн байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2009 оны жилийн эцсийн байдлаар нийт 212 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Тусгай зөвшөөрөлтэй хоршоодын орон нутгийн байршлыг графикаар харуулбал:



Хадгаламж, зээлийн хоршоодын нийт актив өмнөх оны мөн үеэс хугацаатай хадгаламж 2,226,542.0 мянган төгрөгөөр өссөнөөр нэмэгдэж, нийт актив 44,568,177.8 мянган төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт активын /**банкны салбарын нийт актив 4,421,769,179.7 мянган төгрөг**/ 1.0 хувь, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 32,215,209.7 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт олгосон зээлийн /**2,742,249.365.0 мянган төгрөг**/ 1.2 хувь, нийт хадгаламжийн үлдэгдэл 29,898,255.7 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт хадгаламжийн үлдэгдлийн /**1,794,918.680.3 мянган төгрөг**/ 1.7 хувьтай тус тус тэнцэж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээний хавсралт зээл, хадгаламжийн хүүгийн судалгааг 159 хоршоо буюу нийт хоршоодын 75.0 хувь нь гаргаж ирүүлсэн бөгөөд судалгаанаас харахад валютын зээлийн хүүгийн судалгааг гаргаж тирүүлсэн 13 хоршоо байгаагаас валютын зээлийн хүүгийн дээд хэмжээ 2.5-6.0 хувь, валютын зээлийн хүүгийн доод хэмжээ 1.5-3.0 хувьтай байна.

Харин валютын хадгаламжийн хүүгийн судалгааг ирүүлсэн 15 хоршоо байгаагаас валютын хадгаламжийн дээд хүүгийн хэмжээ 0.7-2.0 хувь, валютын хадгаламжийн хүүгийн доод хэмжээ 0.2-1.5 хувьтай байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа системийн хувьд 20.3 хувьтай байна.



Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээг 2007-2009 он хүртэлх байдлаар харуулбал дараах байдалтай байна.



Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 2008 оны 1 улиралд 31.6 тэрбум төгрөг байсан бол 2009 оны байдлаар жилийн эцсийн байдлаар 30.1 тэрбум төгрөг байна. 2007-2009 онуудад хадгаламжийн хэмжээ 25.9-29.9 тэрбум төгрөгийн хооронд байна.

Харин хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 6.5-7.4 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. 2009 оны жилийн эцсийн байдлаар 7.4 тэрбум төгрөг байна. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 2009 онд 14,076,859.70 төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлсийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тухайн тайлант хугацааны санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг цаг хугацаанд нь авч хэвшсэнээр нэгтгэлийн тоон мэдээллүүд үнэн зөв гарч, цаашид ямар арга хэмжээ авах талаар зөв бодлого боловсруулах боломжтой.

Иймд цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, мэдээгээ журмын дагуу гаргаж цаг хугацаандаа ирүүлдэггүй, 2 ба 3 улирал дараалан санхүүгийн тайлан ирүүлээгүй хоршоодын үйл ажиллагааг Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын биелэлтэд анхаарч ажиллах;
2. Хоршооноос ирүүлж буй улирлын санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хоршооны дарга, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон нягтлан бодогч, зээлийн мэргэжилтнээр мэргэжлийн, ур чадвартай хүмүүсийг авч ажиллуулж байгаад анхаарах, тэдгээрт тавих шаардлагыг нэмэгдүүлэх, Монголын хоршоодын холбоо, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвтэй хамтран холбогдох сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах;
3. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны эрх зүйн үндэсийг боловсронгуй болгохтой холбогдуулан хуулийн төсөлд өөрчлөлт оруулж холбогдох яам, эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж, хэлэлцүүлэн, батлуулах;
4. Шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох заавар, журмуудыг шинэчлэн боловсруулах, боловсронгуй болгох;
5. Газар дээрх болон зайнаас тавих хяналтын чанар үр нөлөөг сайжруулахад анхаарч ажиллах;
6. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх;

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР